

## МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГАЧЛАЛ, ЗАРИМ АСУУДАЛ

### ORGANIZATION OF THE PROFESSIONAL TRAINING, AND SOME ISSUES



#### С.БАТТӨМӨР

ХСИС-ийн Онцгой байдлын сургуулийн Гал түймэртэй тэмцэх албаны тэнхимийн багш, онцгой байдлын дэд хурандаа

#### BATTUMUR S.

Lecturer of the Emergency Management School, Law Enforcement University, Lieutenant Colonel

**Товч агуулга:** Аврах, гал унтраах үйл ажиллагааг оновчтой, ухаалаг, шуурхай гүйцэтгэхэд аврагч, гал сөнөөгчийн сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэл чухал нөлөөтэй байдаг. Мэргэжлийн сургалт бэлтгэл нь маш олон хүчин зүйлсээс хамааралтай, олон хэсэг бүхий нарийн төвөгтэй үйл явц бөгөөд судалгаанд сургалт бэлтгэлийн онцлог, шаардлагыг судалж, бэлтгэлийн арга замуудыг тодорхойлж, тэдгээр нь авран хамгаалах үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж болохыг судалсан болно.

**Abstract:** Psychological, physical and skill training of rescuers and firefighters is a crucial to perform rescue and firefighting operations rationally, intelligently and efficiently. This training depending upon many factors, is a complex process with many components. This research studies the characteristics and requirements of psychological, physical and professional skills training and as well as the ways of training-preparation and shows their effect for the rescue and firefighting operations.

Аврагч, гал сөнөөгчдийн сэтгэл зүй, бие бялдар, мэргэжлийн ур чадварын бэлтгэлийн үндэс нь биеийн хүчний сургалт, дасгалжуулалт байдаг. Сургалт дасгалжуулалтын үндэс нь биеийн хүчний дасгалжилтанд сургах - сурах үйл явцын салшгүй хэсэг байдаг бөгөөд дараахи үйл ажиллагааны суурь болж өгнө.<sup>1</sup> Үүнд: зайлшгүй мэдлэг дамжуулах, тодорхой чадвар, дадал бий болгох, тодорхой чадварыг хөгжүүлэх явдал юм.

Сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын сургалт дасгалжуулалт нь багаар ажиллах, хамтарсан үйл ажиллагаа явуулж үр дүнд хүрэхэд зайлшгүй шаардлагатай боловсронгуй болгох үйл явц юм. Сургалт, дасгалжуулалт нь сэтгэл зүйтэй холбоо бүхий дараах хүчин зүйлүүдээс хамааралтай байдаг. Тухайлбал: мэдлэг эзэмших чадвар, ажигч байдал, биеийн хүчээ дайчлах чадвар, багаж зэвсэглэмж ашиглах техник суралцах явдал гэж үздэг.

Сургалт дасгалжуулалт нь хүмүүжүүлэх ач холбогдолтой бөгөөд сургалт

<sup>1</sup> Т.Лхамжав . “Гал унтраах сэтгэл зүйн бэлтгэл” УБ. 2001. 32 тал

дасгалжуулалтын үр дүнд тухайн хүний сэтгэл зүйтэй холбоо бүхий санаачилгатай, шаардлагатай, эр зоригтой, сахилга баттай, нөхөрсөг, хамт олонч, эх оронч гэх мэт шинжүүд хөгжиж төлөвшинө. Сургалт нь багшаас үлгэр үзүүлэх, шавиас ойлгон хүлээн авч дууриах үйл явцын нэгдэл байдаг бөгөөд үлгэр, дуурайлалын нэгдэл бүрдэх нь сургалтанд нэн чухал ач холбогдолтой байдаг. Хүлээн авч, төсөөлөлдөө үндэслэн хөдөлгөөн давахыг дууриах гэнэ.<sup>2</sup>

Дууриах үйл нь онол, практикийн сургалт, хөдөлмөрт хандах хандлага, албаны мэргэжлийн сургалтанд аль алинд нь илэрч байдаг. Дууриах нь хоёр хэлбэрээр амьдралд тохиолддог.

- Урьдчилан төлөвлөгөөгүй, зориуд механикаар дууриах
- Урьдчилан төлөвлөж, ухамсартайгаар идэвхитэй дууриах.

Албаны төрөл мэргэжлийн сургалтын нарийн нийлмэл хөдөлгөөнийг механикаар хуулбарлаж болохгүй тул түүнийг дээд зэргээр анхаарч, ухамсарлан мэдэрч, идэвхитэй суралцахыг зайлшгүй шаарддаг. Албаны төрөл мэргэжлийн нарийн нийлмэл хөдөлгөөнийг шинээр хийж сурахад урд нь хийж сурсан, дадсан хөдөлгөөн их нөлөөтэй. Хэрвээ хөдөлгөөн нь буруу хэвшиж тогтсон бол муугаар нөлөөлдөг. Нарийн нийлмэл хөдөлгөөнийг шинээр хийж сурах нь олдмол хөдөлгөөн бөгөөд төрөлхийн хөдөлгөөний чадварт (явах, зогсох, суух, гүйх гэх мэт) үндэслэн хөгждөг.

Хөдөлгөөнийг дууриахад аврагч, гал сөнөөгчдийн хувь хүний онцлог ихээхэн чухал ач холбогдолтой байдаг ба түүнийг гүйцэтгэхэд нэн түрүүнд биеийн галбир, дээд мэдрэлийн ажиллагааны хэв шинж, авир араншин зэрэг хувь хүний онцлогууд нөлөөлнө. Сургалт дасгалжуулалт нь нэг талаараа мэдлэг дамжуулах үйл явц бөгөөд мэдлэг дамжуулах үйл явц нь дараах гурван зүйлтэй нягт холбоотой байдаг. Үүнд: сурч буй хөдөлгөөний техникийн онцлогийн талаархи төсөөлөлтэй байх, хөдөлгөөнийг зөв хийх зүй тогтолтой байх, хөдөлгөөний зөв хэвшилтэй байх.<sup>3</sup>

Хөдөлгөөний төсөөллийн тухай мэдлэгийг хамгийн үр ашигтай дамжуулахын тулд хөдөлгөөн ойлгомжтой байх, хөдөлгөөн алдаагүй байх, хөдөлгөөнийг сайн ажигласан байх гэсэн гурван зарчмыг баримтлана. Хөдөлгөөний зүй тогтлыг зөв сургахын тулд сэтгэл зүйн талаасаа дараах зүйлийг бодолцох ёстой байдаг. Үүнд: тухайн аврагч, гал сөнөөгчдийн сэтгэцийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, хөдөлгөөнийг тооцоотой зөв хийх явдал юм.

Хөдөлгөөний хэвшил нь практик чадвар, дадлаар илрэн гардаг. Чадвар дадал олгох физиологийн үндэс нь давтах үйл явцтай салшгүй холбоотой. Давталт нь физиологийн талаасаа нөхцөлт рефлекс тогтоох зүй тогтлын салшгүй нэг хэсэг билээ. Давталтаар хөдөлгөөний үр дүн тооноос чанарт шилжих, улмаар энэ нь практикт хөдөлгөөний хэвшлээр илэрдэг. Хөдөлгөөний хэвшил тогтоох үйл явц хөдөлгөөнийг тайлбарлах, мэдрүүлэхээс эхэлнэ. Хөдөлгөөний талаар нэн түрүүнд зөв төсөөлөл бий болгох хэрэгтэй. Үүний тулд:

- Хөдөлгөөнийг удаан ойлгомжтой хийж харуулна
- Хөдөлгөөнийг янз бүрийн ачаалалтай хийж гүйцэтгэнэ
- Сурч буй хөдөлгөөнөө сонгон, хэсэг хэсгээр гүйцэтгэж сурах
- Хөдөлгөөнийг тайлбарлахдаа дохионы тогтолцоог үр ашигтай

хослуулан хэрэглэх (дасгал хийж байхдаа түүнийг тайлбарлах хэрэгтэй

<sup>2</sup> Ч.Хатанбаатар "Тамирчны эрхэм ёс" УБ. 2000 он

<sup>3</sup> Д.Ганболд "Сургалт дасгалжуулалтын арга техник" илтгэл 2008 он

гэсэн үг)

- Хөдөлгөөнийг тайлбарлах нэр томъёог оновчтой хэрэглэх

**Сургалт дасгалжуулалт.** Сургалт дасгалжуулалт хоёр нь өөр хоорондоо салшгүй холбоотой. Сургалт дасгалжуулалт нь хөдөлгөөний хэвшил тогтооход баримтлах ерөнхий үндэс болохын зэрэгцээ аврагч, гал сөнөөгчдөд эр зориг, ёс суртахууний хүмүүжил олгоход нэн чухал үүрэгтэй. Сургалтын гол зорилго нь биеийн хүчний дасгалыг зөв гүйцэтгэх арга барилд сургана. Дасгалжуулалтын гол зорилго нь тухайн төрлөөр техник тактикаа боловсронгуй болгож амжилт гаргах, бие бялдараа хөгжүүлэх, зайлшгүй шаардлагатай чанарыг эзэмшүүлэхэд чиглэнэ. Сургалтаар мэдлэг чадвар, дадал эзэмшиж, дасгалжуулалтаар эдгээрийгээ цаашид улам боловсронгуй болгодог.

**Сургалтыг ойлгомжтой байлгах сэтгэл зүйн үндэс.** Сургалт ойлгомжтой байх сэтгэл зүйн үндэс нь нэн түрүүнд тодорхой төсөөлөлд үндэслэдэг. Нөгөө талаар сургах үйл явц хэрхэн зөв илэрхийлэгдэж байгаагаас хамаарна. Сургалтанд илэрхийллийг хөдөлгөөнөөр, үгээр хослон үзүүлэх зайлшгүй шаардлагатай байдаг. Сургалтыг ойлгомжтой байлгахын тулд мэдрэхүйн эрхтний бүх боломжийг ашиглах хэрэгтэй. Албаны ур чадварын сургалтыг ойлгомжтой явуулахад хөдөлгөөний үзүүлбэр шийдвэрлэх үүрэгтэй байдаг бөгөөд үүнээс үүдэн дасгал хөдөлгөөнийг алдаагүй зөв үзүүлэх шаардлага тавигддаг.

Энэ нь сургагч, дасгалжуулагч багш, суралцагч, аврагч, гал сөнөөгчдийн нүдэн дээр тухайн хөдөлгөөнийг зөв чадмаг хийж үзүүлэхийг зүй ёсоор шаарддаг. Хөдөлгөөнийг хийж гүйцэтгэхэд дараах шаардлага тавигдана:

- Аврагч гал сөнөөгчдөд зааж буй хөдөлгөөнийхөө онцлогыг ухамсарлуулах хэрэгтэй. Үүний тулд сургагч, дасгалжуулагч, багш хөдөлгөөнөө үзүүлэхийн өмнө түүнийг ярьж тайлбарлана.

- Сургалтанд хамрагдаж байгаа аврагч, гал сөнөөгч нарын анхаарлыг татаж төвлөрүүлэх ёстой. Энэ нь багшийн хийж буй хөдөлгөөний үзүүлбэр суралцагчдын сонирхлыг өөрийн эрхгүй татаж байх ёстой гэсэн үг.

- Үзүүлсэн хөдөлгөөнийхөө онцлогыг үгээр бататгах ёстой.

**Албаны мэргэжлийн уралдаан тэмцээний үед илрэх, сэтгэл зүй, бие бялдар, мэргэжлийн ур чадварын тухай ерөнхий ойлголт.**

Сургалт тэмцээн нь аврагч, гал сөнөөгчдийн үйл ажиллагааны хамгийн чухал салшгүй хэсэг юм. Ажил мэргэжлийн уралдаан тэмцээнгүйгээр аврагч, гал сөнөөгчдийн сэтгэл зүй, бие бялдар, ур чадварыг хөгжүүлэн , аврах, гал унтраах үйл ажиллагаанд бэлтгэгдсэн боловсон хүчнийг бэлтгэх, баг бүрдүүлэн ажиллах гэсэн ойлголт байж болохгүй юм. Мэргэжлийн чиглэлийн уралдаан тэмцээн нь сургалт хүмүүжлийн нэн чухал ач холбогдолтой. Мэргэжлийн сургалт тэмцээн нь аврагч, гал сөнөөгчдөд хөдөлгөөний хэвшил тогтох , эерэг зан төлөв, эр зориг хөгжихөд асар их нөлөөлдөг. Мэргэжлийн сургалт тэмцээний хүмүүжлийн ач холбогдол бүхий сэтгэл зүйн онцлогууд

- Мэргэжлийн сургалт тэмцээний оролцогч бүр ялахыг эрмэлздэг .
- Мэргэжлийн сургалт тэмцээн нь аврагч, гал сөнөөгчдөөс бие сэтгэлийн дээд зэргийн ачаалал ,чадвар шаардана. Иймд мэргэжлийн

сургалт тэмцээний үед анхаарал, хүртэхүй, эр зориг, хурд хүчээ дайчлах чадвар нэмэгдэнэ.

- Сэтгэл хөдлөл дээд зэргээр хүчтэй илэрнэ.
- Өөртөө итгэлтэй байх чадвар бий болно.

Аврагч, гал сөнөөгчдийн тактик, арга зүйн бэлгэлийн сэтгэл зүйн үндэс. Мэргэжлийн сургалт тэмцээнд амжилт гаргахад чиглэсэн тодорхой арга барил хэрэглэхийг тактик, арга зүй гэнэ. Тактикийн үндэс нь: мэдлэг, чадвар, дадалд тулгуурлана. Мэдлэг гэдэг нь:

- Тактикийн чадварын тухай мэдлэг (хүчээ зөв хувиарлах г.м.)
- Өөрийн хувийн онцлогийн тухай мэдлэг (биеийн онцлогт тулгуурлан тухайн тактикаа ашиглан амжилт гаргах боломж )
- Өрсөлдөгчийн онцлогийг мэдэх (Техник, тактик, алдаа )
- Болох гэж буй мэргэжлийн сургалт тэмцээний нөхцөлийг мэдэх (зам, зай талбайтай урьдчилан танилцах)
- Дүрэм зааврын мэдлэг
- Мэргэжлийн сургалт тэмцээний өвөрмөц онцлогийн мэдлэг

Дээр дурдсан мэдлэгийг амьдралд хэрэгжүүлж байвал чадвар болох бөгөөд хэвшил болсон тохиолдолд дадал болж хувирна.

Мэдлэгт тулгуурлан гүйцэтгэх үйлдлийг эзэмших үйл явц нь чадвар, дадал гэсэн хоёр шаттай явагдана: Чадвар нь: олж авсан мэдлэгээ практикт ашиглан тухайн үйл ажиллагаагаар амжилтад хүргэх үйл явц. Мэргэжлийн сургалт бол биеийн хүчний аль нэгэн дасгалыг амжилттай гүйцэтгэхтэй холбоотой (сэлэх, гүйх, харайх г.м) илэрнэ. Дадал нь: тоо чанарын хувьд дээд зэргийн үр дүнтэй хурдан, зөв хэмнэлттэй гүйцэтгэж буй боловсронгуй үйл юм. Дадлын гол шинж нь: <sup>4</sup>

- Гүйцэтгэж буй үйл нь иж бүрэн байх
- Гүйцэтгэлээ ухамсарлах
- Сургалт, хүмүүжлийн ажил, амьралын туршлагын явцад үүсч хөгждөг
- Хөдөлгөөн нь автомат болно.

Энэ бүх шинжийн физиологийн үндэс нь мэдрэлийн динамик холбоотой бөгөөд хөдөлгөөний дадал бий болгож хөгжүүлэх үйл явц түүний техникээс ихээхэн шалтгаална. Тухайлбал:

- Хөдөлгөөний техник зөв байх
- Хөдөлгөөний техник тогтвортой байх
- Хөдөлгөөний техник янз бүрийн аргаар хийх бололцоотой байх
- Хөдөлгөөний техник нөхцөл базорилго өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор хувиргах чадвартай байх.

Хөдөлгөөний техник дээрхи байдлаар төгөлдөржсөн тохиолдолд жинхэнэ аврагч, гал сөнөөгч болно. Хүний амьдралын явцад үүсч хадгалагдсан ямар нэг үйлийг боловсронгуй болоход чиглэсэн хандлагыг зуршил гэж нэрлэдэг. Тухайлбал өглөө бүр биеийн тамирын дасгал хийдэг зуршил тогтсон хүнд дадлын хөгжил төлөвшихөд цаашдаа гурван үндсэн хувилбар байж болдог. Үүнд:

- Урьд нь олж авсан дадал шинийг эзэмшихэд таатай нөлөөлөх
- Урьд нь олж авсан дадал шинийг эзэмшихэд эсрэгээр нөлөөлөх
- Урьд сурсан хөдөлгөөний бүтэц шинээр эзэмшиж буй хөдөлгөөний

<sup>4</sup> Д.Тунгалаг “Ёс зүй” мэргэжлийн ёс суртахуун ба мэргэжлийн ёс зүйн онцлог УБ.2002. 131 тал

эсрэг байвал сурцыг удаашруулах

Хөдөлгөөний техникийг урьд нь буруу эзэмшсэн байвал хөдөлгөөний дадал саармагжих ба үгүй болох, бий болсон автомат үйл ажиллагаа сулрах, эсвэл бүр мөсөн алга болох магадлал өндөр байдаг. Тухайлбал удаан хугацаагаар дасгал сургууль хийхгүй завсарлах, хэт ядрах, ачаалал хэтрэх, хойрогшин хандах, гадны хэт хүчтэй ер бусын цочролын нөлөө зэргээс хөдөлгөөний техник алдагддаг.<sup>5</sup>

**Аврагч, гал сөнөөгчдийн сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын онцлог.** Аврагч, гал сөнөөгчдийн сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын онцлог нь мэргэжилдээ амжилт гаргах чухал хүчин зүйл болдог бөгөөд тактикийн сэтгэл зүйн үндэс болно. Гал түймэр унтраах арга зүй, тактикт нөлөөлөх аврагч, гал сөнөөгчдийн сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын онцлог болох ажигч байдал, ухаарах чадвар, санаачилгатай байдал, урьдчилан харах чадвар зэргийг хамгийн түрүүнд авч үздэг.

Ажигч байдал нь гал түймэр, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх явцад эгзэгтэй агшинуудыг хурдан, зөв үнэлэх чадвартай байх, ухаарах чадвар нь баримт сэлтийг хурдан зөв үнэлж, ач холбогдол үр дагаварыг нь тооцоолох чадвартай байх, санаачилгатай байдал нь тактикийг хурдан шийдвэртэй хэрэгжүүлэх, хамгийн ашигтай үйл ажиллагааны арга барилыг бие даан сонгон хэрэглэх чадвартай байх, урьдчилан харах чадвар нь тактик, арга зүйн төлөв байдлыг урьдчилан тааж өөрийнхөө үр дүн, үйлдлийг урьдчилан харах чадвар гэж ойлгож болно.

Тактик нь мэргэжлийн сургалт бэлтгэлээс ихээхэн хэмжээгээр хамаарна. Тактикийн бэлтгэл нь удаан хугацааны зорилго чиглэлтэй, сурган хүмүүжүүлэх үйл явц юм. Тактикийн бэлтгэлийг техникийн бэлтгэлтэй хамт явуулна. Тактикийн бэлтгэлийн зорилго нь тухайн мэргэжлийн тактикийн онцлог, үр ашигтай тактикийн арга барилыг хэрэглэх нөхцөл эзэмших, энэ арга барилаа практикт хэрэглэж чадах дадлагатай болох явдал юм. Тактикийн бэлтгэлийн сэтгэл зүйд хамгийн чухал нөлөөтэй нь сэтгэлгээ юм.

Тактикийн зорилгыг хэрэгжүүлэх аврагч, гал сөнөөгчдийн сэтгэлгээний онцлог тактикийн чадвар нь цагийн байдал, тасралтгүй өөрчлөгдөх нөхцөл байдалд зөв хурдан үнэлгээ өгч, үүнтэйгээ уялдуулан өөрийнхөө тактикийг боловсруулж тухайн нөхцөлд хурдан, үр ашигтай хэрэглэхэд оршино. Үүнд чухамхүү тухайн аврагч гал сөнөөгчдийн сэтгэлгээний онцлог хэрэг болдог. Тактикт нөлөөлөх аврагч, гал сөнөөгчдийн сэтгэлгээний онцлог, тактикийн төлөвлөгөөтэй байх ба энэ төлөвлөгөөг гаргахын тулд:

- Гамшгийн хүч, сэтгэл зүйн онцлог тактикийн боломжийг мэдэх
- Цагийн байдалд өөрчлөгдөх үйлдлийг урьдчилан мэдэх
- Өөрийнхөө боломжийг зөв үнэлэх
- Багаж зэвсэглэмж, хэрэгслэлийг зөв сонгох, техниктэй дадсан байх
- Хийх үйлдэл тодорхой, ойлгомжтой байх
- Шийдэмгий, анхааралтай байх
- Хурдан сэтгэх, шургуу байх
- Сэтгэлийн эр зоригтой байх
- Өөртэйгөө ярих, өөртөө тушаах

Тактикийн сэтгэлгээ нь их тархины гадрын идэвхитэй үйл ажиллагаа бөгөөд өвөрмөц дасгалаар тактикийн сэтгэлгээг сайжруулна.

**Аврах, гал унтраах үйлдлээ төлөвлөх.** Үйлдлээ төлөвлөх нь дараах зүйлд

<sup>5</sup> “Сургалтын сэтгэл зүйн зарим асуудлууд” илтгэл УБ.2014

чиглэнэ. Тохиолдож болох бэрхшээлийг урьдчилан харж ухамсарлах, бэрхшээлийг давж туулах арга хэрэгслэлийг сонгох, аврах, гал унтраах арга зүйн төлөвлөгөө нь дараах гурван хэлбэртэй байж болно.

- Аврах гал унтраах арга зүйн энгийн төлөвлөгөө (туулах замыг тооцсон)
- Аврах гал унтраах арга зүйн нийлмэл төлөвлөгөө (олон зүйлийг тооцсон)
- Аврах гал унтраах арга зүйн илүү нормт төлөвлөгөө (болзошгүй зүйлүүдийг нэмж төлөвлөнө)

Гал унтраах удирдагчийн төлөвлөгөө нь нэн түрүүнд дараах гурван шаардлагыг хангасан байна Үүнд: цагийн байдлыг бодитой тооцоолох, бүтээлч арга барилын хувьд баян байх, баримжаалсан байх шаардлагатай.

**Өөртөө тушаал өгөх.** Энэ үйл нь нэг дохионы тогтолцоотой нягт холбоотой бөгөөд энэ байдал нь хөдөлгөөнөөр илэрнэ. Нөгөө талаар өөртөө тушаал өгөх нь сэтгэл хөдлөл ихтэй байдаг, иймээс хурдан оновчтой хөдөлгөөн хийх бололцоо олгоно.

**Аврагч гал сөнөөгчдийн бие бялдарын бэлтгэлийн онцлог:** Бие бялдарын бэлтгэл аврагч, гал сөнөөгчдийн зоригийн чанарыг хөгжүүлэх үйл ажиллагаа юм. Мэргэжлийн сургалтын үйл ажиллагааны гол онцлог нь бэрхшээлийг даван туулахдаа холбоотой эр зоригийн бэлтгэл нь санаачилгатай, шийдэмгий, эрэлхэг, эр зоригтойгоор бэрхшээлийг сөрөн зогсож даван туулах онцгой чадварт үндэслэнэ.

Бие бялдарын чанарын сэтгэл зүйн онцлогууд нь эерэг, сөрөг шинжүүдийн харилцан уялдаанд илэрнэ. Үүнд: эрэлхэг-аймхай, итгэлтэй-хувирамтгай, шургуу-сул, тэвчээртэй-тэвчээргүй гэх мэт. Эдгээр шинжийн эерэг талыг хөгжүүлэхэд сургалт дасгалжуулалтын зорилго оршино. Бие бялдарын чанарын сэтгэл зүйн онцлогууд нь дээд мэдрэлийн үйл ажиллагаатай хамааралтай, тухайлбал эрэлхэг шийдэмгий, туйлбартай байх нь хүчтэй тэнцвэртэй, хөдөлгөөнтэй байх физиологийн үндэстэй, бие бялдар ур чадварын сул шинж үйл ажиллагаа нөхцөлт рефлексийн замаар гэнэт хямрах, булчин сулрах, зүрх дэлсэх гэх мэт шинжээр илэрнэ.

Дээд мэдрэлийн үйл ажиллагааны талаас самуурч анхаарлаа төвлөрүүлж чадахгүй байх, гаж буруу мэдрэмж төсөөлөл бий болох, буруу ойлгох улмаар сааталд орох зэрэг нь үндэслэлгүй шийдвэр гаргахад хүргэнэ. Тодорхой хугацаанд цочрох эсвэл саатсанаас болж өөрийн хүчиндээ итгэхгүй болж хүч нь суларч хийж байгаа үйлдлээ үргэлжлүүлэх сониорхолгүй болно. Бие бялдар, ур чадварын сөрөг, сул шинжтэй тэмцэх хоёр үндсэн арга зам байж болох юм.<sup>6</sup>

- Урьд нь тохиолдсон сэтгэлийн хүнд цохилтыг мартагнуулж, бэрхшээлийг даван туулахад нь идэвхитэй туслах

- Бие бялдарт сөрөг илрэлийн саатлын үйл явцыг бэхжүүлэх замаар ухамсартай дарангуйлах явдал юм. Үүний тулд: эр зоригийн дасгалжилт хийх, сөрөг нөхцөлийг арилгах, өөртөө итгэх, урам хайрлах

Бие бялдар, ур чадварын бэлтгэл түүний ач холбогдол нь ухамсартайгаар бэрхшээлийг даван туулахад чиглэнэ. Бие бялдар ур чадварын хэлбэрүүд нь дараах байдлаар илэрдэг. Биеийн хүчний ачааллыг тэсвэрлэх, анхаарлыг дээд зэргээр төвлөрүүлэх, ядралтыг тэсвэрлэх, айдас бэрхшээлийг давах, тухайн цаг үеийн сэтгэл түгшилтийг даван туулах гэсэн үндсэн зарчмууд дээр тулгуулагддаг

<sup>6</sup> Д.Эрдэнэчулуун "Сурагчдын сэтгэцийн онцлогийг судлах арга зүй" Мөрөн. 1995



Эр зоригийн чанарыг бий болгох аргад бага зэргийн саатлаас эхэлж тавьсан зорилгыг гүйцэтгэх хүсэл төрүүлэн гүйцэтгэж чадна гэдэгтээ итгэхээр хүндхэн даалгавар өгөх, хурдан эрчимтэй гүйцэтгүүлэх, анхаарал нь төвлөрөхөөр даалгавар гүйцэтгүүлэх, эр зоригийн чанарыг удаан үргэлжлүүлэх чадвар суулгах аргачлал байж болно.

**Аврах гал унтраах үйл ажиллагаанд тохиолдох бэрхшээл түүний онцлог.** Аврах, гал унтраах үйл ажиллагаанд тохиолдох бэрхшээлийг объектив, субъектив гэж хоёр хувааж болох юм. Объектив бэрхшээл нь тухайн үүрэг гүйцэтгэх үед тохиолдож болох өвөрмөц бэрхшээл бөгөөд түүнийг даван туулахгүйгээр аврах, гал унтраах үйл ажиллагааг бүрэн төгс явуулж чадахгүй. Жишээлбэл: биеийн хүч, хурд оновчтой байдал, хөдөлгөөний дээд зэргийн тэнцвэртэй байдал. Энэ бэрхшээлийг даван туулах арга нь зөв байх учиртай.

Субъектив бэрхшээл нь тухайн аврагч, гал сөнөөгчийн үүрэг гүйцэтгэх объектив онцлог сургалт дадлагын нөхцөлд аврагчдын хувийн харьцаанаас хамаарч гарч ирнэ. Жишээлбэл гэмтэл авахаас айх, хамтран үүрэг гүйцэтгэж буй нөхдөө болон өөрийгөө хэт үнэлэх гэх мэт. Энэ бэрхшээлийг даван туулах гол арга нь итгүүлж, үнэмшүүлж, зөв ойлгуулахад оршино. Аврах, гал унтраах үед илрэх сэтгэл хөдлөлийн онцлог шинжид сэтгэл хөдлөл хурц, хүчтэй илэрнэ. Сэтгэл хөдлөл аврагч, гал сөнөөгч нарын үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөөлөхийн зэрэгцээ сэтгэл хөдлөлөө жолоодохыг шаардана. Сэтгэл хөдлөл янз бүрийн хэлбэрээр тод илрэх бөгөөд сэтгэл хөдлөл хурдан хувирна.

Сэтгэлийн хямрал, хөөрөл, эсвэл уналт ихэвчлэн хэт ачааллаас илэрнэ. Сэтгэлийн хямрал хүнд хэцүү, аюултай үүрэг гүйцэтгэхтэй холбоотой үүсдэг. Гэхдээ энэ нь ерөнхий ажиллах чадварыг нэмэгдүүлж, эрэлхэг тэвчээртэй өөрийн хүчинд итгэдэг, бэрхшээлийг даван туулах чадвартай болгодог сайн талтай. Харин амжилтгүй байвал эсрэгээр нөлөөлдөг. Удаан хугацаагаар эрчимтэй үргэлжлэх гал түймэр, гамшиг ослын голомтод тодорхой агшинд үүсдэг өвөрмөц байдлыг үхэлд хүргэх мөч гэж нэрлэж болно. Энэ үед сэтгэл зүйн дараах онцлог илэрдэг:

- Ухаан балартаж, бие баларч, сэтгэхүй, ой ухаан суларна.
- Анхаарал сарнина, аврагч нарын тогтвортой байдал эрс буурна.
- Амьсгал давхцаж, зүрх зогсох мэт мэдрэмжтэй холбоотой сэтгэлийн хүнд байдалд орно.

- Хөдөлгөөний идэвх буурч, хөл хүндэрч, цааш нь үргэлжлүүлж чадмааргүй болж, байрлалаа орхин гарах хүсэл төрнө.

**Хүний үндсэн үйл ажиллагааны сэтгэл зүйн онцлог.** Хүний үндсэн үйл ажиллагаа хөдөлмөрлөх, сурах, тоглох гэсэн гурван цуврал үйлээр илэрнэ. Хөдөлмөрлөх үйл нь хүн бий болгосон анхны нөхцлийн нэг гэдэгт хэн ч эргэлзэхгүй биз ээ. Энэ үйл нь хүсэл, чиглэсэн зорилго, үйлдэл хэмээх гурван цуврал үйл ажиллагааны нэгдэл юм. Хүсэл нь хүний хэрэгцээн дээр үндэслэн бий болж, чиглэсэн зорилгыг төрүүлнэ. Чиглэсэн зорилго тавьж үр дүнд хүрэх үйл нь зорилгоо хэрэгжүүлж үр дүнд хүрэхийн тулд хийж буй үйлдэл. Хөдөлмөрлөх үйлийн нэг тод жишээ нь төрөл мэргэжлийн алба гэж ойлгож болно. Хөдөлмөрлөх үйлийн явцад ажигч байж тухайн хийх ажлын дэс дарааллыг гүн гүнзгий ойлгох, арга техникт маш сайн суралцах, шургуу хөдөлмөрлөх явдал юм. Сурах үйл нь хүн төрөлхтний хуримтлуулсан мэдлэгийг эзэмших үйл явцад мэдлэг, чадвар, дадал гэсэн гурван шаттай болж амьдралд хэрэгжинэ.<sup>7</sup>

<sup>7</sup> Т.Соронзонболд, П.Цэдэв "Аврагчдын сургалтын мөн чанар, тогтолцоог боловсронгуй болгох арга

**Техникийн бэлтгэлийн үеийн сэтгэл зүйн үндэс.** Биеийн хүчний дасгалын техник нь тухайн дасгалыг дээд зэргээр үр ашигтай гүйцэтгэх аргуудын нийлбэр юм. Хөдөлгөөний дээд зэргийн дадал хөгжүүлэх нь биеийн хүчний дасгалыг зөв хийх техникт сургах зорилготой. Албаны сургалтын бэлтгэлийн өвөрмөц хувилбарыг техникийн бэлтгэл хэмээн нэрлэдэг. Биеийн хүчний дасгал гүйцэтгэхэд мэдрэмжийн үүрэг, хөдөлгөөний тэнцвэрийн, хүрэлцэх мэдрэмж гэж хуваан үздэг бөгөөд өөрийн өвөрмөц үүрэгтэй.

Хөдөлгөөний мэдрэмж нь хөдөлгөөний уялдаа холбоог хангахад чухал үүрэгтэй дараах зүйлүүдийг мэдрэх онцлогтой байдаг Үүнд: хүчийг мэдрэх, эсэргүүцлийг мэдрэх, хүчдэлийн үргэлжлэх хугацаа, өөрчлөлтийг мэдрэх, хөдөлгөөний хурдыг мэдрэх, уян хатан далайцыг мэдрэх хэрэгтэй байдаг. Тэнцвэрийн мэдрэмж нь огцом эргэлттэй, хурдтай хөдөлгөөн шаардах, мөн шүхрээр буух үеийн эргэлдэх хурд орж болох ба хүрэлцэх мэдрэмж нь аливаа зүйлийн хэлбэр, хэмжээ хатуу зөөлөнг мэдрэх үүрэгтэй. Органик мэдрэмжийн ачаар өвдөлтийг мэдэрч, гэмтэж бэртэхээс сэргийлж, амь насаа хамгаалах боломж бүрдэнэ.

**Биеийн хүчний дасгалыг гүйцэтгэхэд хөдөлгөөний хүртэхүйн үүрэг.** Өөрийнхөө хөдөлгөөнийг дасгалын үед хүртэх нь нарийн нийлмэл үйл бөгөөд дараах зүйлүүдийг хүртэж байдаг. Биеийн болон түүний хэсгийн байрлалыг хүртэх, хөдөлгөөнийг идэвхийг хүртэх, хийж буй хөдөлгөөний хэмжээг хүртэж төсөөлөх. Энэ хүртэхүй нь дараах мэдрэмжинд тулгуурладаг: Анхны барилтай холбоотой мэдрэмж, хөдөлгөөн хийхэд хөдөлгөөн хийж буй эрхтэн өөрчлөгдөж буй мэдрэмж, булчингийн ширхэгийн уртын өөрчлөлттэй холбоотой гарах булчингийн мэдрэмж, тодорхой өндөрт өргөхөд эрхтэнд хүнд нь мэдрэгдэх, хөдөлгөөний чиглэлийг хүртэх харааны мэдрэмж чухал.

Хөдөлгөөний хурдыг хүртэх гэдэг нь биеийн хүчний дасгалын үед хугацааг төсөөлөх төсөөлөл нь тодорхой хугацаанд гүйцэтгэх ёстойг аль болох богино хугацаанд хийх хугацааг мэдэж, хүчээ зөв хувиарлахад тусална. Биеийн хүчний дасгалын үед хугацааг төсөөлөх нь дараах зүйлд үндэслэнэ: Тодорхой зайн дахь алхалтын тоогоор, энерги зарцуулалтаар, дохиогоор хөдөлгөөний хурдыг тооцоолдог.

Гамшиг осол, гал түймрийн аюулаас хамгаалах гол арга бол урьдчилан сэргийлэх, үе шаттай сургалтыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу системтэй зохион байгуулах явдал бөгөөд аврах арга хэмжээг аль болох шуурхай гүйцэтгэх шаардлага тавигдаж байна. Гамшиг, ослын аюулаас иргэдээ хамгаалах гол арга, хэлбэр бол аврагч нарыг болон иргэдийг аврах үйл ажиллагаанд сургасан байх явдал юм. Чухам юунд сургагдах ёстойг аврах ажиллагаанд оролцсон туршлага, сургамжаар тодотгож, аврагчдын сургалтын онол, практикийг тодорхойлж болно. Тийм учраас аврагч нарын үндсэн хөдөлмөр бол аврах ажиллагаанд суралцах явдал гэж томъёолж болно. Өөрийн амь биеийг золиослон байж, иргэдийн амь насыг аврахад суралцах явдал бол хүнд хөдөлмөрийн нэг гэж дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн байдаг учраас дэлхий хамгийн хүнд мэргэжилд гал сөнөөгч нарыг оруулсан байна.

Олон улсын хэмжээнд онцгой байдлын мэргэжилтэнг гүйцэтгэх үүрэгтэй нь уялдуулан чадамж эзэмшүүлэх, гал сөнөөгч, аврагч мэргэжлийг эрчимтэй, мэдээлэлжсэн технологиор богино хугацаанд, чанартай суурь боловсрол олгохын зэрэгцээ онцгой байдлын албаны ажилтаны мэдлэгийг гүйцэтгэх үүргийн хэмжээнд

зам” илгтэл, 2013 он



эзэмшүүлэхэд анхаарах болжээ.

Судалгаанаас үзэхэд төв, орон нутгийн аврах, гал унтраах анги, салбарын захирагч нар нь бүлэг, салаа, салбарын түвшинд боловсрол эзэмшсэн байгаа ч аюул осол, байгалын гамшиг тохиолдсон үед тухайн салбарыг өргөтгөн зохион байгуулахад бэлтгэгдээгүй байгаа зэргээс харагдаж байна. Дээрх байдлаас үзвэл, мэргэжлийн аврагч нарыг бэлтгэх, түүний тогтолцоо, сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тулгарч байна.

### **Дүгнэлт**

Хууль сахиулахын их сургуулийн Онцгой байдлын сургуулийн сургалтын хөтөлбөрт биеийн хүчний болон албаны спорт, хавсарсан мэргэжлээр практик сургалтын бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнд хүрэх хамгийн дөхөм арга бол сургалтын үйл ажиллагааг бодит байдалд ойртуулж гал унтраах бэлтгэл сургалт болон албаны сургалтын арга техник хичээлийн явцад нь спорт болон биеийн тамирын төрөл, дасгалуудыг нийцүүлэх замаар загварчлал боловсруулах явдал юм. Энэхүү загварчлалын үндэс нь мэргэжлийн програмчилсан норматив хугацааны тооцоо байх юм.

Норматив хугацааны тооцоололд сургалтын нөхцлийн дэлгэрэнгүй тайлбар, түүний онцлог шинж чанарууд, мөн хувь хүний зан чанар, сэтгэлзүйн болон биеийн хүчний гол ач холбогдолтой чанаруудыг дэлгэрэнгүй тайлбарласан бичилтүүд байх.

“Онцгой байдлын ажил-эрх зүй” мэргэжлээр бэлтгэгдэж буй мэргэжилтэнгүүдийн мэргэжлийн үйл ажиллагааны цар хүрээ, хэрэгцээ шаардлагад тулгуурлан мэргэжлийн програмчлал тооцоог гаргаж, зөвхөн гал түймрийг унтраах төдий биш аюулгүй байдлын бүрдэлт, урьдчилан сэргийлэх зорилго бүхий ажлуудыг зохион байгуулах дараахь мэргэжилтэнгүүдийг бэлтгэх хэрэгтэй гэж үзэж байна. Үүнд:

Төрөл мэргэжлийн аврагч, гал сөнөөгч, инженер - зохион байгуулагч, байгаль орчин хамгаалагч, төрөл мэргэжлийн удирдагч гэсэн чиглэлээр байж болох юм. Эдгээр мэргэжлийн сургалтанд хамрагдаж байгаа хүний биеийн хүчний онцлог чадваруудын дотроос хамгийн чухал нь:

- Ачаалал даах чадвар
- Анхаарал төвлөрүүлэх чадвар
- Онцгой байдалд бэлтгэлтэй байх чадвар
- Цаг агаарын болон газар зүйн ямар ч нөхцөлд сэтгэл зүйн, биеийн хүчний бэлтгэлтэй ба ачаалал даах чадварууд юм.

“Онцгой байдлын ажил - эрх зүй” мэргэжлээр суралцаж байгаа сонсогчдын сургалтын үйл ажиллагаанд дараахь бие сэтгэлийн шинж чанаруудын үзүүлэлтийг зайлшгүй шаарддаг байх ёстой. Тухайлбал: харааны болон сонсголын, ой тогтоолтын хүрээ, харааны хэмжээ, хуваарилалт, анхаарлын тогтоц, төвлөрөл, сэтгэл зүй, шаламгай байдлын тогтоц зэргүүд болно.

Мөн энэхүү мэргэжлийн чиглэлд хувь хүний чанарууд маш чухал. Үүнд: өндөр сахилга бат, дэг журам, зориг, шийдвэртэй байх, зорилготой, овсгоо самбаа, хатуужилтай байх ёстой. Зохион байгуулах чадваруудад өөрийгөө удирдах, бие дааж шийдвэр гаргах, бусдыг удирдах, удирдагч хүнд байх ёстой бүхий л зан чанаруудыг агуулна. Суралцагч оюутнууд хөдөлгөөний чадварыг эзэмших, хавсарсан хэлбэртэй аврах ажиллагаанд суралцах, эд зүйлс болон эд зүйлсгүй аюулд орсон хүнийг зөөх, өгсөх, уруудах алхмаар яаравчилсан шилжих хөдөлгөөн хийх, мөлхөө хөдөлгөөн, олс бусад багаж зэвсэглэмж ашиглан ханаар авирах, тусгайлсан төхөөрөмжүүд дээр яаравчилсан шилжих хөдөлгөөнүүдийн хийх, хоёроос гурван метрийн өндөрт хөдөлгөөн хийх, багаар ажиллах чадвар суулгах сургалтуудыг зайлшгүй зохион байгуулах, сургалтын материаллаг баазыг бий болгох хэрэгтэй байна.